

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Мод бэлтгэлийн ажил. Аюулгүй ажиллагааны шаардлага	MNS XXXX:XXXX
Occupational safety and health. Occupational safety. Wood preparation. General safety requirements	MNS 12.3.007:1972-ийн оронд

Стандарт хэмжил зүйн газрын даргын оны дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны.....дүгээр сарын-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь мод бэлтгэлийн ажилд хамаарч, түүнийг гүйцэтгэх үеийн аюулгүйн ажиллагааны шаардлагыг тогтооно. Энэ стандарт нь мод бэлтгэлийн үйлдвэрлэл, эрхэлсэн үйлдвэр, аж ахуйн нэгж газруудад хамаарна.

2. Нэр томьёо, тодорхойлолт

2.1 Мод цагаалалт

Мод боловсруулах үйлдвэрлэлийн явцад модон материалын гадаргууг өнгөлж, тэгшилж, өө сэв, бохирдол, зураасыг арилгах зорилгоор хийдэг боловсруулалтын процесс юм.

2.2 Амгаа авалт

Мод боловсруулах, зүсмэл материал үйлдвэрлэлийн явцад материалын ирмэг, зах хэсгийг тэгшлэх, тодорхой хэлбэрт оруулах зорилгоор хийдэг боловсруулалтын үйл ажиллагааг хэлнэ.

2.3 Штабель

Материал (ихэвчлэн модон материал, зүсмэл материал, банз, гуалин зэрэг)-ыг тогтсон хэмжээ, хэлбэр, стандартын дагуу давхарлан, эмх цэгцтэйгээр өрж байрлуулсан овоолго, бөөгнөрөл юм.

3. Ерөнхий зүйл

3.1 Зорилго

Мод огтлох, тээвэрлэх, ачих, буулгах зэрэг бүх шатны үйл ажиллагааны явцад ажилчдын эрүүл мэнд, амь, нас, тоног төхөөрөмж болон хүрээлэн буй орчныг гэмтэл, осол, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

4. Ерөнхий шаардлага

4.1 Мод бэлтгэлийн ажлыг ой, модны аж үйлдвэрийн яамны баталсан “Мод

бэлтгэлийн ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн болон энэ стандартын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

4.2 Аюулгүй ажиллагааны шаардлага хангасан машин механизм, тоног төхөөрөмж, моторт хөрөө хагас механикжсан хэрэгсэл /шингэнт шаантаг, шахуурга г.м/-ийн тусламжтайгаар мод бэлтгэх ажлыг гүйцэтгэнэ.

4.3 Мод бэлтгэлийн ажил гүйцэтгэж байгаа ажилчдыг хавсралтад дурдсан үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийн үйлчлэлээс хамгаалах урьдчилсан арга хэмжээг авсан байна.

5. Технологийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

5.1 Мод бэлтгэлийн ажлыг аюул осолгүй гүйцэтгэх технологи нь дараах замаар хангагдана. Үүнд:

- Технологийн үйл ажиллагааны бэлтгэх ба туслах шатны арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Үйлдвэрлэлийн байр дахь осолтой бүсийг аюулгүйн тэмдгээр хязгаарлах;
- Үйлдвэрлэлийн явцад хүн ба машин, механизмыг ажиллахад аюулгүй зайд байрлуулах;
- Үйлдвэрлэлийн талбай, мод тээврийн зам, ажлын байрыг нормын дагуу гэрэлтүүлэх;
- Ажлын байрыг галын аюулаас хамгаалах багажаар хангах.

6. Мод бэлтгэх ажилд тавигдах шаардлага

6.1 Мод тайрах газар дахь мод унагалт, цагаалалт мөчирлөгөө, тууш модны тайралт, талбайн цэвэрлэгээ болон бэлтгэх, туслах ажлууд нь мод бэлтгэлийн ажлын аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байвал зохино.

6.2 Тухайн газар нутгийн рельефийн онцлог, ойн бүтэц, мод бэлтгэх арга, ашиглагдах машин, тоног төхөөрөмж, болон хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч мод тайрах талбай бүрд технологийн картыг зохиосон байна.

6.3 Технологийн картад мод тайрах талбайн тодорхойлолт, хэрэглэлийг харуулсан мод тайрах талбайн бүдүүвч зураг, мод тээврийн ба цагаалгын зам, туслах, тоног төхөөрөмжийг байрлуулах талбай, аюулгүй бүс зэргийг тусгасан байна.

6.4 Мод тайрах ажлыг эхлэхийн өмнө мод тайрах газрыг болон ачих талбайг бэлтгэх, мастерийн хэсгийг байгуулах, мод тээврийн салаа зам ба нэмэлт цагаалгын зам гаргах, канатан төхөөрөмжийг угсрах зэрэг бэлтгэл ажил хийгдэнэ. Мод тайрах талбайн бэлтгэл ажилд осолтой модыг зайлуулах, цагаалгын төв ба салбар замыг тэмдэглэх, харин өндөр уулсын мод тайрах талбайн хувьд нэмэлт канатан төхөөрөмж байгуулах зэрэг ажлууд орно. Мод тайрах ажилд шилжихдээ эхлэлтийн акт үйлдвэл зохино.

ТАЙЛБАР: Гэмтэлтэй модонд салхины нөлөөлөл цохилт буюу түлхэлтээс унаж болзошгүй өмхөрсөн, хуурайшиж хатсан өлгөгдөж дүүжлэгдсэн салхи, шуурганд хугарсан моднууд хамаарна. Хэрэв бүх модны 20-иос дээш хувь нь гэмтэлтэй мод бол мод тайрах талбайн бэлтгэл ажил хийгдэхгүй. Иймд уг талбайг салхи, шуурганд авсан талбайн дүрмийн дагуу боловсруулах ёстой. Ойн цэвэрлэгээний

тайралтаар гэмтэлтэй модыг тайрч зайлуулсан байвал зохино. Модыг машин механизмаар унагахад гэмтэлтэй модыг унагаж зайлуулсан байвал зохино. Гэмтэлтэй модыг хожуул дээр орхихыг хориглоно.

6.5 Мод бэлтгэж байгаа газраас тойргоороо 50 м-ийн гадна дээд агуулах, бэлтгэсэн модыг ачих талбай, зөөврийн цахилгаан станц, лебедок дулаацах байр, хоол унд хүлээж авах газрыг байрлуулна. Эдгээрийг ой дотор байрлуулах бол түүний ойролцоо байгаа аюул учруулж болзошгүй модыг унагаж зайлуулсан байвал зохино.

6.6 Мод бэлтгэлийн талбайн зам ба зөрлөгийг аюулгүйн тэмдэг тэмдгээр хязгаарласан байна.

6.7 Мод унагаж байгаа газраас тойргоороо 50 м-ийн доторх зайг осолтой бүс гэх ба түүнээс дотогш нэвтэрч орохыг хориглосон нэгдсэн загварын зөөврийн тэмдгийг аюултай бүсийн зааг дээр буюу цагаалгын замын ойролцоо үзэгдэхүйц газар байрлуулсан байна.

6.8 Мод тайрах талбайн хилээс гадагш осолгүй бүс нь 150 хүртэл газрын налууд 60 м, 150-аас дээш налууд уулын бэл хүртэл байна.

6.9 Мод тайрах талбайн доторх осолгүй бүс нь мод бэлтгэх болон бусад төрлийн ажилбар хийгдэж буй хэсгүүдийн хооронд 60м, мод унагалтаас бусад төрлийн ажилбар эрхэлж буй хэсгүүдийн хооронд 30м, 150 хүртэл ба түүнээс дээш налуутай газарт мод огтлох ажил гүйцэтгэж буй хэсгүүдийн хооронд 60 м ба мод унагалтаас бусад төрлийн ажилбар эрхэлж буй хэсэгт уулын бэл хүртэл байна.

6.10 Осолгүй бүсийг аюулгүйн тэмдгээр хязгаарласан байна.

6.11 Мод унагалтад тавих шаардлага

6.11.1 Мод бэлтгэлийн ажилд аюулгүйн ажиллагааны шаардлага хангасан моторт хөрөө мод унагах багаж хэрэгслийг хэрэглэнэ.

6.11.2 Салхины хурд 8.5 м/сек-ээс дээш үед уулын мод тайрах талбайд мод унагах цагаалах, мөчирлөх, тууш мод тайрахыг, салхины хурд 11м/сек-ээс дээш үед тал газарт мод унагахыг, салхины хурд 4.5 м/сек-ээс үед ганцаарчлан мод унагахыг тус тус хориглоно. Аадар бороо, аянга, цахилгаан, өтгөн манан /үзэгдэх чадвар 50 м-ээс дотогш/- тай үед мод огтлох ажлыг зогсоосон байвал зохино.

6.11.3 Мод унагаж байгаа үед осолтой бүсэд модны эргэн тойрны цасыг цэвэрлэх, унагасан модыг мөчирлөх оосорлох, цагаалах, мөчир шатаах зэрэг ажил гүйцэтгэхийг хориглоно.

6.11.4 Бензин моторт хөрөө ба мөчирлөгчөөр ажиллах үед дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ хөдөлгүүр асаалттай үед түлш шатахуунаар цэнэглэх ба шатахуунд этилтэй бензин хольж хэрэглэхийг хориглоно.

б/ нэг модноос нөгөөд шилжихдээ хөдөлгүүрийн эргэлтийг багасгаж гинжээ хөдөлгөөнтэй болгоно.

в/ бензин моторт хөрөө /мөчирлөгч/-нд бага зэргийн засвар, хийх түүний гинжийг солих буюу чангалах, хэвтээ чиглэлээр хөрөөдөж байгаад босоо чиглэлд шилжүүлэн хөрөөний редукторыг эргүүлэх зэрэгт хөдөлгүүрийг заавал унтраана.

г/ хөдөлгүүрийг бүрэн унтарсны дараа мод зуултаас хөрөөний гинжийг гаргаж авах хэрэгтэй.

6.11.5 Гар ба моторт хөрөөгөөр мод унагахын өмнө ажиллахад саад болох бут,

сөөгийг зайлуулсан байх ба өвлийн нөхцөлд модны эргэн тойрон дахь цасыг цэвэрлэж мод унагах зүгийн эсрэг чиглэлд 450-ийн өнцөг үүсгэн 4 м-ээс багагүй ухрах зам гаргасан байна.

6.11.6 Моторт хөрөөгөөр модыг унагахдаа дараах зүйлүүдийг анхаарч ажиллавал зохино. Үүнд:

а/ унагах хэрэгсэл /шингэнт шаантаг, шингэнт өргөгч, унагах, ац, хүрз, шаантаг/- ийн тусламжтайгаар ажиллана.

б/ салхи, шуурганд унасан ба түймэрт автсан модтой ойд мод тайрах цэвэрлэгээний, шилэн сонголтын түүвэр тайралтын үед мөн 200-аас дээш налууд мод тайрах талбайг тайралтад бэлтгэхэд болон унагах механикжсан хэрэгсэлгүйгээр 22 см-ээс дээш голчтой модыг тайрахад хоёр ажилчин /унагагч, түлхэгч/ ажиллах ёстой.

в/ модны унагах талаас амгаа авалтыг голчийн $1/4$ -ээс $1/3$ хүртэл гүнд хийнэ.

г/ амгаа авалтыг хийхдээ эхлээд хэвтээ чиглэлд модны босоо тэнхлэгт эгц хөндлөн хөрөөдөх бөгөөд дараа нь түүнээс дээгүүр 25-350-ийн өнцөг үүсгэхээр тооцоолон уг хөрөөдсөнтэй уулзуулан хөрөөднө. Эсвэл хоорондоо голчийн аравны нэгээс багагүй зайтайгаар зэрэгцээ хоёр хөрөөдөж дунд тайрдсыг сүхээр цохиж авна.

д/ амгаа авалтын дараа эсрэг талаас нь хэвтээ чиглэлд хөрөөднө. Энэ нь амгаа авалтаас дээгүүр байвал зохино.

е/ унагах зүг рүү хазайсан модонд амгаа авалтыг шаантаг хэлбэрээр хийх хэрэгтэй

ё/ 6.11.14-р заалтаас бусад тохиолдолд 5 градусаас дээш хазайсан модыг налсан зүг рүү нь унагана.

6.11.7 Салхи, шуурганд автсан буюу шатсан ойд мод боловсруулалт хийх, цэвэрлэгээний тайралтыг явуулахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ мод унагахын өмнө өлгөгдсөн мөчрийг зайлуулж, осолтой модыг унагана.

б/ орой нь хугарч газарт хүрсэн боловч үндэстэйгээ холбогдсон хэсгийн холболтын бат бөхийг шалгаж үзэхгүйгээр уг модыг хөрөөдөж унагахыг хориглоно.

в/ үндэсний систем нь гэмтэж хазайсан модыг хазайсан зүгт нь унагана.

г/ салхи, шуурганд унасан модтой талбай нь 30 см-ээс зузаан цастай бол ажиллахыг хориглоно.

6.11.8 Дүүжлэгдсэн модыг трактороор буюу 35 м-ээс урт татлагатай лебедокоор татаж буулгана.

6.11.9 Нэг ба хэд хэдэн дутуу хөрөөдсөн модыг нөгөөгөөр нь цохиж бөөнөөр унагахыг хориглоно.

6.11.10 Түүвэрлэх ба цэвэрлэгээний, зам гаргах тайрах үед модыг унагаж цагаалахад саад болох гэмтэлтэй модыг тайрч зайлуулсан байвал зохино.

6.11.11 Зулзган модны төгөл, үндсээрээ нийлж ургасан модыг хазайж ургасан зүгт нь унагана.

6.11.12 Харанхуй бүрэнхийд гар ба моторт хэрэгслээр мод унагахыг хориглоно.

6.11.13 Завсарлагааны үе буюу ажил дууссаны дараа талбайд дутуу хөрөөдөгдсөн дүүжлэгдсэн мод орхиж явахыг хориглоно.

6.11.14 150-аас дээш налуутай мод тайрах талбайд газрын налуу дагуу модыг унагана.

6.11.15 25 градусаас дээш налуутай, 30 см-ээс дээш цасан хунгартай талбайд гар ба моторт хэрэгслээр мод унагахыг хориглоно.

6.11.16 Харанхуй бүрэнхийд бэлтгэсэн модыг машинаар тээвэрлэж байгаа үед мод бэлтгэсэн талбайн зам, зөрөг аюултай бүсийг аюулгүйн хориглох тэмдгээр

хязгаарласан байх ёстой.

6.11.17 Салхи, шуурганд унасан модтой бэлтгэлийн талбайд механизмаар мод унагахыг хориглоно.

6.11.18 Мод унагагч машины техникийн баримт бичигт зааснаас дээш хэмжээний голчтой модыг унагаж болохгүй. Уг модыг тайрч эхлэхээс өмнө газрын түвшингээс 1м-ийн өндөрт 10 см-ээс багагүй өргөнтэйгөөр эргэн тойрон холтослох хэрэгтэй. Эдгээр модыг цагаалга эхлэхээс өмнө моторт хөрөөгөөр унагасан байна.

6.11.19 Техникийн баримт бичигт нь зааснаас илүү налуутай талбайд механизмаар мод унагахыг хориглоно.

6.11.20 Мод унагагч механизмаар модыг үндэстэй нь унагах, түүвэр арчилгаа цэвэрлэгээний тайралт хийхийг хориглоно.

6.12 Мод цагаалгад тавих шаардлага

6.12.1 Мод цагаалгад хэрэглэгдэж байгаа трактор дүүжинт канатан төхөөрөмж, мод бэлтгэлийн лебедок, дүүжинт блокууд нь аюулгүйн ажиллагааны шаардлага хангасан байвал зохино.

6.12.2 Трактороор мод цагаалахын үед цагаалгын замыг нь тусгайлан засаж янзалсан байна. Цагаалгын замыг засах үед том хэмжээний мод чулууг зайлуулах, бут сөөгийг тайрах хожуулыг газрын хөрстэй нь тэгшлэн тайрах нүхийг таглах, намгархаг газрыг хайргаар өнгөлж далдлах, уулын налуу хэсэгт бол зам зэрэг арга хэмжээ авсан байвал зохино. Цагаалгын замын өргөн 5 м-ээс, харин уулын налуу хэсэгт зассан замын өргөн 7 м-ээс тус тус багагүй байна.

6.12.3 Гинжит трактороор мод цагаалах үеийн замын налуу нь өвөл ба зуны бороотой улиралд 15 градус, зуны хуурай /гантай/ улиралд 25 градусаас тус тус ихгүй байна. Уулын налууд хөндлөн зассан цагаалгын зам нь хөндлөн огтлолоороо хэвтээ байрлалтай байна.

6.12.4 Трактороор мод цагаалахад дараах шаардлагуудыг мөрдөж ажиллах хэрэгтэй. Үүнд:

а/ цагаалах тууш модыг тайрц талаас нь 0.5-аас 0.7 метрт, үзүүр талаас нь 0.9-өөс 1,2 хүртэл метрт оосорлосон байна.

б/ тууш модыг багцалж цуглуулах үед тракторын төв тэнхлэг нь багцын хөдөлгөөний чиглэлтэй давхацсан байвал зохино.

Трактороор модыг цагаалах үед:

- Тракторын хөдөлгөөн дунд ба гол татлага чангарсан үед хожуулын завсар хавчуулагдсан тууш модыг суллах;
- Чангарч байгаа канатан татлага дээгүүр давж гарах, тракторын хөдөлгөөн дунд оосорлох гогцоог засах, тайлах, тууш модыг оосорлох;
- Тракторын бүхээгийн гадна талд болон цагаалж байгаа тууш мод /багц/ дээр сууж явах;
- Тракторын хөдөлгөөн дунд бууж суух, бүхээгээс толгой цухуйлгаж явахыг тус тус хориглоно.

6.12.5 Канатан цагаалах төхөөрөмжийг тооцооны ачааллаас 25%-иас дээш хэмжээтэй статистик ачааллаар туршсаны дараа мод цагаалгад хэрэглэхийг зөвшөөрнө. Тооцооноос 10 хувь их ачааллаар динамик туршилт явуулна.

6.12.6 Канатан төхөөрөмжийн тулгуурыг цуураагүй, өмхгүй модоор хийх бөгөөд үзүүр талын голчийн хэмжээг тооцоогоор тодорхойлж тогтооно. Тулгуурын

мод нь бат бөхийн нөөцөөс 24 дахин их байх ёстой.

6.12.7 Тулгуурыг гурваас доошгүй татуургаар бэхлэх ба татуурга нь зангуутай болон тулгууртай холбож бэхлэх уртын хэмжээг үл тооцон тулгуурын өндрөөс 1.5 дахин урт байна.

6.12.8 Цагаалах төхөөрөмжийн тээвэрлэгч канат, тулгуурын татлага, блокыг 25 см- ээс багагүй голчтой, 0.3-аас 0.5 м хүртэл өндөртэй, үндэс нь гэмтээгүй, эрүүл хожуулд эсвэл гагнасан ба булагдсан зангуунд сайтар бэхэлсэн байх хэрэгтэй.

6.12.9 Тулгуурыг тоноглох, түүнд канат блокын төхөөрөмж угсрахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ тулгуурт хамгаалах бүс, хумсны тусламжтайгаар авирна.

б/ тулгуурын үзүүрийг тайрах ба мөчирлөх үед гар хөрөө хэрэглэх, бөгөөд оройн хэсгийг гар харуулаар холтослоно. Энэ зорилгоор сүх, моторт хэрэгсэл хэрэглэж болохгүй.

в/ тайрагдсан үзүүрийг хожуулд бэхэлсэн гурван татуургын тусламжтайгаар зайлуулна. Тулгуурын оройг тайрах ба мөчирлөх үед уг модноос эргэн тойрон 15м-ийн радиуст хүн ажиллахыг хориглоно.

г/ тулгуурын оройд бэхэлсэн угсрах блокийн тусламжтайгаар блок, канат бусад багаж хэрэгслийг өргөнө.

6.12.10 Блок-канатан төхөөрөмжийг газар дээр угсарч, тулгууруудыг трактор болон лебедокын тусламжтайгаар суурилуулна.

6.12.11 Канатан цагаалагч төхөөрөмж дээр ажиллаж байгаа бригадууд нь хоорондоо харилцан дохионы төхөөрөмжөөр холбогдсон байх ёстой.

6.12.12 Мод цагаалах замаар тууш мод /гуалин/-г буулгахдаа технологийн картанд заасан горимын дагуу гүйцэтгэвэл зохино.

6.12.13 Мод буулгах замын дагуу аюултай бүсийн өргөн нь 15 градус хүртэл налуу газарт 60 м /хоёр талд 30м/, 15-аас 30 градус хүртэл -120 м /хоёр талд 60 м/ 30- аас дээш градус бол уулсын бэл хүртэл байна.

6.12.14 Ажил эхлэхээс өмнө дохио өгөгч хүмүүсийг мод буулгах замын дагууд ажиллаж байгаа ажилчин ба мод тээврийн явцыг бүрэн ажиглаж болох тохиромжтой байранд байрлуулсан байна.

6.12.15 Гуалинг уулнаас буулгахын өмнө доод талбайгаас түрүүчийн буулгасан модыг хүлээн авсан ба дараагийнхыг хүлээж авахад бэлэн гэсэн дохиог заавал авсан байна.

6.12.16 Мод бэлтгэсэн талбайн дээд хэсгээс тууш модыг буулгаж эхэлнэ. Мод буулгах замаар бүрэн мөчирлөгдөөгүй гуалинг буулгахыг нэгээс дээш тоотой гуалинг бөөнөөр буулгах завсарлагааны буюу ажил тарсны дараа зам дээр тууш мод /гуалин/ орхиж явахыг тус тус хориглоно.

6.12.17 Мод буулгах замын ханын модны зузаан нь 30-аас 40 см хүртэл байна. Ханын мод нь зай засваргүй нийлж бат бөх холбогдсон байх ёстой. Гуалингуудын уулзвар нь хөдөлгөөний эсрэг хандаж, илүү гарсан байж болохгүй.

6.12.18 Мод буулгах замын дээд талбайд засварын буюу ажлын бус үед тохиолдлоор гуалин унах явдлаас хамгаалсан бэхлэгч хэрэгсэл байрлуулсан байх ёстой.

6.12.19 Харанхуй үзэгдэх орчин хомс үед мод буулгахыг хориглоно.

6.12.20 Бөөрөнхий модон материалыг оосоргүй цагаалагч машин механизмууд нь аюулгүйн техникийн шаардлагыг бүрэн хангасан байвал зохино.

6.12.21 Дугуйт тарктораар 7 градус хүртэл өгсүүр зуны хуурай /гантай/ улиралд 17 градус хүртэл, зуны бороотой ба өвлийн улиралд 13 градус хүртэл уруу газар мод цагаалахыг зөвшөөрнө.

6.12.22 Унагагч буюу унагаж багцлагч механизмаар модыг унагасны дараа унагаж цагаалагч буюу оосоргүйгээр цагаалагч трактораар засаж бэлтгээгүй цагаалгын замаар мод цагаалахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд унагагч ба унагаж багцлагч тракторын мөрийг цагаалгын зам гэж тооцно. Трактор нь багцаар ачсан үед огцом эргэлтгүй аливаа саадыг тойрч/ хожуул, чулуу, нүх гэх мэт / явах хэрэгтэй

6.12.23 Оосоргүйгээр цагаалагч трактораар дүүлжлэгдэж өлгөгдсөн мод авахыг хориглоно.

6.12.24 Харанхуй үзэгдэх орчин хомс үед оосоргүйгээр цагаалагч трактораар мод цагаалахад хоёроос доошгүй механизм хамт ажиллавал зохино.

6.13 Модны мөчирлөгөөнд тавигдах шаардлага

6.13.1 Модны мөчирлөгөөнд хэрэглэгдэж байгаа мөчирлөгч машин, механизм нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

6.13.2 Мод тээврийн болон цагаалгын төв замын дагуу тусгай талбай дээр огтлогдсон модыг мөчирлөгч механизмаар мөчирлөнө. Технологийн картанд талбайн байршилт болон хэмжээг тусгасан байвал зохино.

6.13.3 Мөчирлөгч механизмын ажлын бүсийг аюулгүйн тэмдгээр хязгаарласан байх хэрэгтэй.

6.13.4 Мөчирлөгч механизмын дэргэдэх хураалттай мөчрийг эмхэлж хураах ажил нь зохих хэмжээнд хүртэл механикжсан байна.

6.13.5 Унагасан модыг сүх, моторт хэрэгслээр мөчирлөхөд дараах шаардлагыг мөрдөж ажиллах хэрэгтэй. Үүнд:

а/ тайрцаас үзүүр тал руу мөчирлөх ажиллагааг гүйцэтгэнэ.

б/ 20 градус ба түүнээс дээш налуу газарт дагуу хураасан 15 градус ба түүнээс дээш налуу газарт хөндлөн хураасан гуалинг мөчирлөхийн өмнө газрын дээд талд ойролцоо байгаа хожуултай холбон уясан байна.

6.13.6 Мөчирлөх үед дараах зүйлийг хориглоно. Үүнд:

- Модон дээр мордож буюу зогсож мөчирлөх
- Модыг ойролцоо байгаа хожуултай холбож уяхгүйгээр мөчирлөх;
- Багцалсан тууш модон /гуалин/ дээр мөчирлөх;
- Цагаалагч трактор дээр модыг мөчирлөх;
- Гуалин дамжуулагч дээр мөчирлөх;
- Хураасан гуалингууд дээр мөчирлөх;
- Ялгагдсан модон дээр мөчирлөх;

6.14 Мод бэлтгэх талбай ба дээд агуулах дээр модыг тайрахдаа 6.3-р заалтад дурдсан аюулгүйн ажиллагааны шаардлагыг хангасан байх ёстой.

6.15 200 дээш налуутай мод бэлтгэх талбайд тууш модыг тайрахдаа ойролцоо байгаа хожуултай холбож уях буюу налуу дагуу хөдлөх хөдөлгөөнийг хязгаарлаж ивээс хэрэглэх хэрэгтэй. Уулын налуу хөндлөн хураасан тууш модыг газрын өндөр талаас нь тайрна. Уулын налуу дагуу хураасан тууш модыг хажуу захаас нь налуу, дагуу тайрна. 350 дээш налуутай газарт тууш мод тайрахыг хориглоно.

6.16 Мод бэлтгэх талбайг механикжсан аргаар цэвэрлэхийн өмнө тууш модны

үлдэгдлийг 3-аас 4м-ийн урттайгаар тайрсан байна.

7. Мод тээвэрт тавих шаардлага

7.1 Мод тээврийн автомашин ба төмөр зам нь техник ашиглалтын дүрэм болон хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ёстой.

7.2 Мод тээврийн автомашинд ачсан тууш модыг болон ялгасан модны уртын дунд хэсэгт боогч тоноглолоор бэхэлсэн байх шаардлагатай.

8. Ачих, буулгах ажилд тавих шаардлага

8.1 Тууш модыг ачих, буулгах ажил нь батлагдсан технологийн зааврын дагуу гүйцэтгэгдэнэ.

8.2 Ачаа өргөх машинаар, тухайн хийцийн өргөгч машины техникийн баримт бичигт заасан хэмжээнээс хэтэрсэн, ачаа өргөхийг хориглоно. Ачигч машин механизм нь түүний ачаа өргөхөд зөвшөөрөгдсөн хязгаартай ойролцоо жинтэй ачааг өргөх тохиолдолд, эхэлж ачааг 200-аас 300 мм-ийн өндөрт өргөсний дараа буулгаж, ачигч механизмын тогтвортой байдал, тормозны ажиллагааг шалгах хэрэгтэй.

8.3 Агуулах дахь мод тээврийн зам дагуу байрласан ачих талбай дээрх модон материалыг эмх цэгцтэй хураасан байвал зохино.

8.4 Зэрэгцээ байрласан хоёр штабельд болон нэг штабелийн хоёр талаас нэгэн зэрэг ачих буюу буулгах ажил, ажил гүйцэтгэхийг хориглоно.

8.5 Мод тээврийн автомашин нь тууш модыг ачих ба буулгахын өмнө тормозны ажиллагааг сайтар шалгасан байх шаардлагатай.

8.6 Тууш модыг ачих ба буулгах үед дараах шаардлагыг мөрдлөг болгох ёстой. Үүнд:

а/ Өргөгч тоног төхөөрөмжийн гогцоог ачааны хүндийн төвд тохируулсан байна.

б/ Ган канат бүрэн суларч авто краны траверс буусан үед ачааг оосорлох буюу салгах ажиллагааг гүйцэтгэнэ.

в/ Оосрыг ачааны доогуур оруулахдаа зориулалтын тоноглолын тусламжтайгаар гүйцэтгэнэ.

г/ Хүндийн төвөөс ижил зайд ачааг оосорлоно.

д/ Оосорлосон ачааг 0.5 м-ээс багагүй өндөрт өргөн зөөвөрлөнө.

е/ Өргөгдсөн гуалин /багц гуалин/-г залахдаа зориулалтын дэгээ буюу 5 м-ээс багагүй урттай олс хэрэглэнэ.

8.7 Гуалин /тууш мод/-г ачих ба буулгах үед автомашины бүхээг дотор, тэвш дээр, ачаа зөөвөрлөж байгаа бүсэд хүн байхыг хориглоно. Тууш модыг байнга ачих буулгах зориулалттай талбай нь аюулгүйн тэмдгээр хязгаарлагдсан байх ёстой.

8.8 Модон материалыг ачих

8.8.1 Тууш мод /гуалин/-ыг автокранаар ачихдаа дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

а/Ажил эхлэхийн өмнө автокран хөдөлгөөнгүй байрласан байна.

б/ Автокраны сумнаас полиспастыг салгасан байна.

в/ Автокраны сумны уртаас тогтоогдсон ачаа өргөх чадвар нь салгаж авсан полиспастын тоогоор буурсан байна.

г/ Автокраны сумны дагуу тэнхлэгтэй ачаа өргөх ган канат давхацсан байна.

д/ ачааг 25 м-ээс ихгүй зайд зөөвөрлөнө.

е/ Ачих талбай нь тэгш бөгөөд хожуулыг газрын хөрстэй тэнцүүлж тайрсан байна.

8.8.2 Ачигчийг ажиллуулах үед дараах зүйлийг хориглоно. Үүнд:

- Түлэгдсэн тууш мод /гуалин/-тай штабелиас модон материалыг ялгах;
- 5м-ээс дээш өндөртэй штабелийг задлах;
- Мод тээврийн автомашины багны хоорондын зайнаас тууш мод /гуалин/-ны урт 1 м-ээс бага бол, түүнийг доод захын эгнээнд хураах;
- Ачааг хөдөлгөөнтэй үед өргөх, буулгах, хазайлгах;
- Аюулгүйн тэмдгээр хязгаарлагдаагүй эрэг, хэвгий газарт /цас буюу ус тогтсон/ штабелийг хураах, задлах.

8.8.3 Модон материалыг төмөр замаар тээвэрлэхдээ ТН 4-514-79, ТН 10-520-79, ТН 2-512-79, ТН 3-513-79, ТН 5-515-79-ийн шаардлагыг хангасан байвал зохино.

8.8.4 Өргөн царигийн төмөр замын платформ ба задгай /хагас/ вагонд бөөрөнхий модон материалыг “малгайчлан” ачих ажиллагаа механикжсан байвал зохино. Богино хэмжээний гуалинг тусгай контейнерээр тээвэрлэж болно.

8.8.5 Модон материалыг төмөр замын тээвэрт ачихдаа аюулгүйн ажиллагааны шаардлага хангах зорилгоор тусгай вандан барьсан байна. Ачих вандангийн тулах элемент, зам, шат нь статистик ачааллаар туршигдсан буюу тооцоогоор батлагдсан байвал зохино.

8.9 Мод тээврийн хөдлөх бүрэлдэхүүнээс модон материалыг буулгах.

8.9.1 Мод тээврийн автомашин нь технологийн картын дагуу буулгах ажиллагааг гүйцэтгэнэ.

8.9.2 Мод тээврийн автомашинаар тууш мод /гуалин/-г буулгах ажил механикжсан байвал зохино.

9. Доод агуулахын ажилд тавигдах шаардлага

9.1 Ширхэгчлэн мөчирлөгч ба бункерэн мөчирлөгчийн ажлын зохион байгуулалт нь норматив техникийн баримт бичгээр тогтоогдсон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байна.

9.2 Мөчирлөгч төхөөрөмжид модыг оруулах, түүнийг огтлогч хутганы дундуур гаргах үеийн аюултай бүсийг хориглох, сануулах тэмдгээр хязгаарласан байна.

9.3 Мөчирлөгч машины мөчир цэвэрлэх ажиллагаа заавал механикжсан байна.

9.4 Нарийн мөчирлөгөө 3.13-р заалтын дагуу гүйцэтгэнэ.

9.5 Тууш модны тайралт

9.5.1 Тууш модны тайралтыг моторт хэрэгсэл, тайрах төхөөрөмж, хөндлөн тайрах дугуй хөрөөгөөр гүйцэтгэнэ.

9.5.2 Тууш модыг ширхэгчлэн тайрахдаа зориулалтын татах төхөөрөмж буюу бусад механизмыг хэрэглэнэ.

9.5.3 Тууш модыг моторт хэрэгслээр тайрахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Моторт хөрөө ажиллаагүй ба кабелиас цахилгаан хөдөлгүүрийг салгасан хөрөөнд жижиг засвар хийх, ирийг солих ба чангалах ажиллагааг гүйцэтгэх;
- Моторт хөрөөний хөдөлгүүрийн бага эргэлтэд /ир хөдлөөгүй үед болон цахилгаан, хөрөөний хөдөлгүүр унтарсан үед нэг модноос нөгөөд шилжих;
- Гүйдэл бүрэн тасарсан үед цахилгаан хөрөөний гинжийг чөлөөлөх

9.5.4 Моторт хөрөөгөөр тууш модыг тайрахдаа зориулалтын вандан дээр гүйцэтгэнэ. Тууш модыг штабель ба багц дээр болон штабель хийх зам дээр тайрахыг хориглоно.

9.5.5 Цахилгаан хөрөөний цахилгаан дамжуулах утас нь тайрах вандангийн дээр 3 м-ээс өндөрт байрласан байна.

9.5.6 Тайрах төхөөрөмж, хагас автомат шугам, хөндлөн тайрах дугуй хөрөөгөөр тууш модыг тайрахдаа дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Ажил эхлэхийн өмнө тайрах төхөөрөмжийн дэргэд гадны хүн байгаа эсэхийг шалгасны эцэст ажиллах дохио өгөх;
- Хөрөө бүрэн эргэлтээ авсан үед тууш модыг тайрах;
- Гүйдэл тасарсан үед тайрах төхөөрөмжийн удирдлагыг унтраах;

9.6 Гуалингийн ялгалт

9.6.1 Гуалин ялгалт нь бүрэн механикжсан байх бөгөөд аюулгүй ажиллагааны шаардлага хангасан гуалин дамжуулагчийн тусламжтайгаар гүйцэтгэгдэнэ.

9.6.2 Гуалин ялгах зориулалттай дамжуулагч нь гуалин түлхэгчээр тоноглогдсон байна. Гуалин түлхэгчгүй нөхцөлд гуалинг гар ажиллагаагаар дамжуулагчаас унагахыг зөвшөөрнө.

9.6.3 Ялгагдсан гуалин нь цуглуулагч /лесонакопитель/-д хураагдана. Цуглуулагчид гуалин хураах үед түүний дэргэд хүн байхыг хориглоно.

9.6.4 Хоёр ба түүнээс дээш цуваа байрласан гуалин дамжуулагчийг ажиллуулахдаа эцсийн дамжуулагчаас эхлэн дэс дараалан асаах ба унтраахдаа мөн эсрэг журмаар гүйцэтгэнэ.

9.6.5 Гуалин ялгах зориулалттай дамжуулагчийг уртын дагууд дурын байрнаас унтраах алсын удирдлагаар тоноглогдсон байвал зохино.

9.7 Бөөрөнхий модон материалыг штабельдаж хураах

9.7.1 Доод агуулахын зохион байгуулалт болон штабелиудын байршилт нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх ёстой.

9.7.2 Бөөрөнхий модон материалын агуулах нь “Модон материалын агуулахын төсөл зохиоход хэрэглэгдэх галын аюулаас хамгаалах норм”-ын шаардлагыг хангасан байна.

9.7.3 Бөөрөнхий модон материалын штабелийн хэмжээ ба маягийг доод агуулахын технологийн үйл ажиллагаа, штабель хийхэд хэрэглэгдэх тоног төхөөрөмжтэй тохируулж сонгоно.

9.7.4 Шигүү, шигүүгээр эгнүүлсэн, багц штабелийг хураах ба задлах ажиллагааг батлагдсан технологийн зааврын дагуу гүйцэтгэнэ.

9.7.5 Бөөрөнхий модон материалын штабелийн өнгөн нь гуалингийн уртын 1/4- ээс ихгүй буюу тухайн штабельд хураагдсан гуалингийн уртын 1.5-аас ихгүй байвал зохино. Гуалинг гар ажиллагаагаар хураасан үед штабелийн өндөр 1.8м- ээс ихгүй байна.

9.7.6 Бөөрөнхий модон материалыг штабельдаж хураах үед дараах шаардлагыг хангасан байвал зохино.

а/ штабель дахь гуалингийн илүү гарах хэмжээ 0.5 м-ээс ихгүй байна.

б/ гуалингийн тайрц талаас 1м-ээс ихгүй зайд дэр модыг штабелийн тууш

тэнхлэгийн дагуу ижил зайд байрлуулна.

в/ эгнээ хоорондын дэр модыг босоо тэнхлэгтэй нэг хавтгайд байрлуулна.

г/ дэр моднууд нь штабелийн дагуу нэг шугамаар тавигдах ба тэдгээрийн үзүүрүүд 1 м-ээс ихгүй зөрсөн байна.

д/ эгнүүлж хураасан штабелийн хоёр хажууг налуу хэлбэрээр хураах ба шинээр хураах эгнээ бүрийг, доод эгнээний хоёр захаас гуалингийн голчтой тэнцүү хэмжээгээр богино хураасан байна.

е/ эгнээ бүрийн захын гуалинг дэр модонд гаргасан хоногт суулгах ба хоногийн гүн хөндлөвчийн зузааны $1/2$ -ээс ихгүй байна.

ё/ шигүү, эгнүүлсэн, багцалсан штабелийн гуалинг нурахаас хамгаалсан хэрэгслээр тоноглох ба уг хэрэгсэл байхгүй тохиолдолд, штабелийг 350- аас ихгүй налуугаар хураасан байна.

9.7.7 Штабельдаж хураах ажиллагаа нь мод бэлтгэлийн талбайд эрүүт ачигчаар, доод агуулахад кран буюу эргүүлэг / лебедка/-ээр гүйцэтгэнэ.

9.7.8 Тууш мод /гуалин/-г штабелийн суурь дээр хураана. Эгнээ бүрийн захын гуалингуудыг ган канат, буюу олсоор багцалж бэхлэсэн байна.

Штабелийн өндөр нь:

- Эрүүт ачигчаар хураасан үед 3м;
- Кабель кранаар хураасан үед 6 м;
- Шөргөн кранаар хураасан үед 7м-ээс тус тус ихгүй байна.

10. Үйлдвэрлэлийн талбай ба ажлын байранд тавигдах шаардлага

10.1 Мод бэлтгэх ажил гүйцэтгэж байгаа талбай буюу байр нь үйлдвэрийн газрын эрүүл ахуйн болон барилгын норм дүрмийн шаардлагыг бүрэн хангаж байх ёстой.

10.2 Үйлдвэрлэлийн талбай, ажлын байр, явган хүний зам, үйлдвэрийн талбай дахь гуалин дамжуулагч зэрэг зохиомол гэрэлтүүлэгтэй байвал зохино.

10.3 Доод агуулахын талбайн элдэв хог хаягдлыг байнга гадагш зөөж цэвэрлэсэн байвал зохино.

10.4 Доод агуулах дээрх модыг тайрах ба боловсруулах ажиллагаа нь хүрээлэн байгаа /агаар, ус, хөрс/ орчноо бохирдуулахгүй байвал зохино.

10.5 Тээврийн хөдөлгөөнийг зохицуулахын тулд үйлдвэрийн талбайд замын тэмдэг, дохионы төхөөрөмжийг байрлуулсан байна.

10.6 Доод агуулахын талбай дахь явган хүний хөдөлгөөнийг зохицуулахын тулд зориулалтын зөрөг, жижиг гүүрийг тавьсан байна.

10.7 Доод агуулах нь барилгын норм, дүрмийн шаардлага хангасан эрүүл ахуйн иж бүрэн комплекстой байна.

10.8 Агаарын 50°C -аас доош температуртай гадаа орчинд буюу үйлдвэрлэлийн байранд мод бэлтгэх ажил явуулж байгаа ажилчдад дулаацах буюу амрах байр, зуны улиралд хур тунадаснаас хамгаалах байрыг мод бэлтгэх талбайд барьсан байна.

10.9 Мод бэлтгэж байгаа талбайгаас 300 м-ээс доошгүй зайд хооллох байр барьсан байна.

10.10 Мод бэлтгэж байгаа ажилчдыг уух усаар байнга хангаж байвал зохино. /дулааны улиралд/

10.11 Мод тээврийн болон самбар, салаа замын төв тэнхлэгээс хоёр тийш 30м хүртэл зай дахь модыг тайрч зайлуулсан байна. / эргэх тойрох зам дээр/

10.12 Дээд агуулах болон мод тээврийн замын дэргэдэх ачих талбайн бут, сөөгийг зайлуулж, хожуулыг газрын хөрстэй тэгшилж авсан байвал зохино.

10.13 Тууш ба ялгасан модыг тэгш, хуурай талбайд хурааж штабелийн гарц, зам, хийлийг заасан тэмдэг байрлуулсан байна.

10.14 Штабелийн дэрийг гуалингаар хийнэ. Модон материалын хэмжээ, штабелийн тоо, хөрсний шинж чанар зэргээс хамааруулж дэр модны тоог тогтооно.

10.15 Гуалин дамжуулагчийн дагуу байрлуулсан гуалин цуглуулагчийн эсрэг талд явган хүний зам зассан байвал зохино.

10.16 Гуалин дамжуулагчийн дагуу ажилчдыг салхи, тундаснаас хамгаалсан битүү ханатай саравч барьсан байна.

10.17 Ачих талбай, тайрах вандангийн тулгуур элементүүдийн бат бөхийг статистик ачааллаар туршиж, тооцоогоор баталсан байна.

11. Мод бэлтгэлийн ажилтан, ажилчдад тавигдах шаардлага

11.1 Мод бэлтгэлийн ажил эрхэлж буй ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, осол, мэргэжлийн өвчнөөс сэргийлэх зорилгоор эмнэлгийн урьдчилсан ба ээлжит үзлэгээр оруулсан байна.

11.2 Мод бэлтгэлийн ажил, машин, тоног төхөөрөмж, моторт хэрэгсэл дээр 18-аас дээш настай, тухайн тоног төхөөрөмж /машин, моторт хэрэгсэл/ дээр ажиллах эрх бүхий мэргэжлийн сургууль төгссөн хүнийг ажиллуулна.

11.3 Моторт ба гар хэрэгслээр мод бэлтгэх, бөөрөнхий модон материалыг ачих, буулгах, штабельдаж хураах ажилд эмэгтэй хүн ажиллуулахыг хориглоно.

11.4 Мод бэлтгэх ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүйн дүрэм болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх талаар зохих сургалтыг төгссөн хүн ажиллах ёстой.

11.5 Мод бэлтгэлийн ажилчид нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дараах сургалтыг төгссөн байна.

Мод бэлтгэлийн ажилчдад:

- Нийт ажилтны сургалт
- Эрсдэлтэй ажлын байрны сургалт

11.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, сургалтыг батлагдсан программын дагуу явуулах ба хичээлийн ирцийг журнал болон бусад баримт бичигт бүртгэнэ.

11.7 Инженер – техникийн ажилчин ажилтнууд ажилд орохын өмнө аюулгүйн ажиллагааны шаардлагын талаар урьдчилсан зааварчилгааг авч шалгалт өгсөн байна.

12. Ажилтны хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэхэд тавигдах шаардлага

12.1 Мод бэлтгэлийн ажилтнуудад хувийн хамгаалах хэрэгсэл зориулалтын гутал, хувцас үнэ төлбөргүй олгогдсон байна.

12.2 Хамгаалах хэрэгсэл нь ажилтнуудын биеийн хэмжээнд тохирсон байна. Ажилчин нь зориулалтын гутал, ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг хүлээн авахдаа тэдгээрийг хэрхэн хэрэглэх талаар зааварчилгаа авсан байвал зохино.

12.3 Мод бэлтгэлийн талбайд ажиллаж байгаа хүмүүс заавал хамгаалах малгай өмссөн байна.

13. Аюулгүй байдлын шаардлагын гүйцэтгэлд тавих хяналт

13.1 Үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн түвшин үзлэг, шинжилгээ хэмжих багажийн тусламжтайгаар байнга хянаж байвал зохино.

13.2 Техник ашиглалтын зааврын тогтоосон хугацаанд мод бэлтгэлийн машин, тоног төхөөрөмжийн техникийн аюулгүй байдлыг тодорхойлно.

ТӨГСӨВ.

СТАНДАРТЫН ТӨСӨГ

Хавсралт А
(мэдээллийн)

Мод бэлтгэлийн ажил явуулах үед үүсэж болзошгүй үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлүүд:

- Хөдөлгөөнт машин ба механизмууд;
- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хамгаалалтгүй хөдөлгөөнт элементүүд, тээвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүн, бэлдэц материалууд;
- Агаарын хэт тоос ба хийжилт;
- Агаарын хэт их, бага температур
- Ажлын байр дахь хэт шуугиан;
- Хэт давтамж;
- Хэт их, бага чийглэг;
- Агаарын хэт хөдөлгөөн;
- Цахилгаан шугам сүлжээн дэх хүчдэл;
- Ажлын бүс дэх тохиромжгүй гэрэлтүүлэг